

**ГХБХБГ-ЫН 05 ДУГААР САРЫН 2 ДАХЬ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,
СУДАЛГАА**

2019.05.09.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Энэ 7 хоногт Өлгий хот дотор шинээр тавигдах 10,4км засмал зам дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын зөрчилтэй газруудыг чөлөөлүүлэх хугацаат мэдэгдэх хуудсыг өгч ажиллаа.</p> <p>Сумдын газрын даамлуудаас тогтмол 7 хоногийн мэдээ авч ажиллаж байна. Тухайлбал:</p> <p>Алтанцөгц сум: Сумын ЗДТГ-аас зохион байгуулсан мод тарих ажилд идэвхтэй оролцов. Мөн бусдын хадлангийн талбайн дундуур зөвшөөрөлгүй шуудуу татаж гаргасан зөрчлийг БОХУ-ийн байцаагчтай хамт газар дээр нь очиж хяналт шалгалт хийлээ.</p> <p>Баяннуур сум: Ажлын төлөвлөгөөний дагуу дотоод ажиллаа өдөр бүр хийж гүйцэтгэж байна. Ард иргэд албан байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг цаг хугацаанд хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж эзэд нь хариу өгч байна.1 иргэний газар эзэмших эрхийг бусдад шилжүүлсэн. 1 иргэнд өмчлүүлсэн газрын хэмжээнд өөрчлөлт оруулах захирамж гаргаж материалыг бүрдүүлж өгсөн.</p> <p>1 иргэний өвөлжөө, хаваржаа, 2 иргэний хадлангийн талбайн маргааныг улмаас томилсон газрын маргааныг шийдвэрлэх комисстой хамтран ажиллаж уг асуудлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.</p> <p>Буянт сум: Энэ 7 хоногт сумын засаг даргын 3 захирамж гаргаж Улсын бүртгэлд илгээн Э дугаар авч ажилласан болно.</p>	<p>Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР